



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/390

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 141 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 205,549,793.1 /хоёр зуун таван сая таван зуун дөчин есөн мянга долоон зуун ерэн гурван төгрөг арван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 141 дүгээр цэцэрлэг /Ц.Мөнхтуул/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 195,644,040 /нэг зуун ерэн таван сая зургаан зуун дөчин дөрвөн мянга дөчин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 9 нэр төрлийн 9,905,753.1 /есөн сая есөн зуун таван мянга долоон зуун тавин гурван төгрөг, арван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 141 дүгээр цэцэрлэг /Ц.Мөнхтуул/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001183



Нийслэлийн Өмчийн Ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А.Б.В. -р тушаалын хавсралт

Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: БГД-ийн 141-р цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХХК-н шийдвэр
1	Проектор	10	ш	1	2,500,000.0	2,500,000.0	2,500,000.0	-	татах
2	Компьютер Samsung	12	ш	1	1,000,000.0	1,000,000.0	1,000,000.0	-	татах
3	Компьютер	13	ш	1	856,254.0	856,254.0	856,254.0	-	татах
4	Компьютер Aser	7	ш	1	750,000.0	750,000.0	750,000.0	-	татах
5	Компьютер	10	ш	1	650,000.0	650,000.0	650,000.0	-	татах
6	Канон Samsung	7	ш	1	650,000.0	650,000.0	650,000.0	-	татах
	Машин тоног төхөөрөмжийн дүн			6		6,406,254.0	6,406,254.0	-	
7	Ногоон хивсэнцэр	9	ш	1	75,000.0	75,000.0	75,000.0	-	татах
8	Хүүхдийн хувцасны шкаф	28	ш	40	80,190.0	3,207,600.0	3,207,600.0	-	татах
9	Мебель тумбочка	19	ш	1	4,000.0	4,000.0	4,000.0	-	устгах
10	Мебель ханын тавиур	19	ш	2	14,850.0	29,700.0	29,700.0	-	устгах
11	Хөгжим Sharp	13	ш	1	216,899.1	216,899.1	216,899.1	-	татах
	Тавилга, эд хогшлын дүн			45		3,533,199.1	3,533,199.1	-	
12	Тоглоомын талбай	28	м2	3634.1	50,000.0	181,705,000.0	181,705,000.0	-	устгах
13	Зулэгжүүлсэн талбай	23	м2	3022.9	4,600.0	13,905,340.0	13,905,340.0	-	устгах
	Бусад үндсэн хөрөнгийн дүн			6657		195,610,340.0	195,610,340.0	-	
	НИИТ ДҮН			6708		205,549,793.1	205,549,793.1	-	
				Үүнээс : Худалдах хөрөнгө					
				Устгах хөрөнгө		195,644,040.0	195,644,040.0	-	
				Татан төвлөрүүлэх хөрөнгө		9,905,753.1	9,905,753.1	-	
				Худалдсанаас олох орлого					
				НӨХГ-т төвлөрүүлэх /30%/					